

Гүйцэтгэлийн аудитын хураангуй тайлан

Огноо: 2020.12.15

Нэг. Ерөнхий мэдээлэл

Аудитын код:	ОРА-2020/05-ГА	Шалгагдсан байгууллага, нэгжийн нэр:	Аймгийн ИТХ, ЗДТГ, ОНӨГ, төсвийн байгууллагууд
Аудитын нэр:	“Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийн явц байдал”		
Аудит хийсэн бүтцийн нэгжийн нэр:	Гүйцэтгэлийн аудитын алба	Аудит хийсэн баг, албан тушаалтан:	Ахлах аудитор В.Жавзмаа, Аудитор Б.Бямбатогтох

Хоёр. Аудитын үр дүн:

2.1 Аудитын зорилго, хамарсан хүрээ:

“Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалт, бүртгэлийн явц байдал”-д аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, аймгийн ИТХ болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн өмчийн харилцааны бодлого, төлөвлөлт хууль, журамд нийцсэн эсэх;
- Орон нутгийн өмчийн харилцаа хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх;

Аудитад аймгийн ИТХ болон ЗДТГ, Орон нутгийн өмчийн газар, төсвийн байгууллагууд, орон нутгийн өмчит аж ахуйн нэгжүүд, орон нутгийн өмчийг түрээсээр ашиглагч байгууллагуудын үйл ажиллагааны тайлан, мэдээг 2017-2019 оны үйл ажиллагааг хамруулсан.

2.2 Аудитын дүн:

2.2.1 Гол асуулт / аудитын дэд зорилт 1:

Орон нутгийн өмчийн харилцааны бодлого, төлөвлөлт хууль, журамд нийцсэн эсэх.

Хариулт 1:

ОНӨГ-ын мөрдөх зарим журмыг шинэчлэн батлах шаардлагатай болсон байна. Тус журмуудыг боловсруулахад мөрдсөн ТӨБЗГ-ын 2017, 2018 оны тогтоолууд нь 2019 онд хүчингүй болж шинэчлэгдсэн байх тул дахин хууль эрх зүйн үндэслэл шаардлагыг хангуулан, журмыг боловсруулан батлах шаардлага үүссэн байна.

Орон нутгийн өмчийн талаар аймгаас баримтлах бодлогыг боловсруулсан хэдий ч мөрдсөн эсэх нь тодорхойгүй байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.1-д “орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах буюу түүнд тавих хяналт шалгалтыг зохион байгуулах”, 77.2.2-т “ИТХ-ын Тэргүүлэгчид, Засаг даргаас орон нутгийн өмчийн хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэрэгжүүлэх талаар зохиосон ажил, үр ашгийн тайлан, нэгдсэн тооллогын дүнг жил бүр хэлэлцэж, дүгнэлт, чиглэл өгөх” гэж заасан байтал аймгийн ИТХ нь ОНӨГ-ын ажлын үр дүнг хэлэлцэж, дүгнээгүй, орон нутгийн өмчийн эд хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдлыг хянан шалгах ажлыг зохион байгуулаагүй байна.

2.2.2 Гол асуулт / аудитын дэд зорилт 2:

Орон нутгийн өмчийн харилцаа хууль журмын дагуу явагдаж байгаа эсэх.

Хариулт 2:

Орон нутгийн өмчийг журмын дагуу бүртгэж буй боловч нэгтгэсэн дүн 818.5 сая төгрөгийн зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Аймгийн Засаг даргын захирамжаар баталсан актлах дүн болон ОНӨГ-ын нэгтгэсэн судалгаанаас үзвэл 2017-2019 онд акталсан хөрөнгө 1,758.7 сая төгрөгийн зөрүү үүссэн байна.

ОНӨГ нь байгууллагуудаас үндсэн хөрөнгийн тайланг авахдаа тухайн байгууллагын үндсэн хөрөнгийн мэдээллүүдийг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д оруулж, санхүүгийн тайлангийн дүнтэй тулган Excel файлд нэгтгэж, ТӨБЗГ-т хүргүүлдэг байна.

Аудитын явцад тус системээс аймгийн орон нутгийн өмчийн нэгтгэл дүнг авч, тулган баталгаажуулах зорилготой байсан боловч систем ажиллахгүй байлаа. Тус систем нь цахим санхүүгийн тайлангийн систем болон бусад системүүдтэй холбогддоггүй, программд мэдээлэл оруулахад ачаалал ихтэй, мэдээлэл дахин ашиглагддаггүй зэрэг дутагдалтай асуудлыг үүсгэдэг байна. Иймд ТӨБЗГ-т системийн ашиглалт, хөгжүүлэлтийг боловсронгуй болгох талаар санал хүргүүлж, үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

ТӨБЗГ-т хүргүүлсэн нэгтгэсэн дүнг байгууллагуудаас судалгаа авч нэгтгэн харьцуулахад 818.5 сая төгрөгийн зөрүү үүссэн болно. Орхон аймгийн ТЭЗ-ийн 2019 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн үндсэн хөрөнгийн дүнг ОНӨГ-ын нэгтгэсэн дүнтэй тулгахад 45,412.2 сая төгрөгийн зөрүү үүсэж байна. Зөрүү үүссэн шалтгааныг ОНӨГ аймгийн Засаг даргын захирамж баталгаажсан тухайн жилдээ акталж амжаагүй бол дараагийн тайлант хугацаанд акталдаг, байгууллагын нягтлан бодогч нар ОНӨГ-т санхүүгийн тайлангаа нэгтгүүлэхдээ аудит хийгээгүй тайлангаа нэгтгүүлдэг гэсэн тайлбар өгсөн болно.

Иймд ОНӨГ-ыг 2017-2019 оны орон нутгийн хөрөнгийн бүртгэлийг орон нутгийн өмчийн хуулийн этгээд бүртэй тулган баталгаажуулж, баталгаажуулсан дүнг аймгийн ТЭЗ-ийн 2020 оны нэгтгэсэн санхүүгийн тайланд үнэн зөв тайлагнуулах арга хэмжээ авч ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Нийт 546.3 сая төгрөгийн анхны өртөгтэй, 39.9 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдаж орон нутгийн төсөвт 72.3 сая төгрөгийг төвлөрүүлжээ. Дуудлага худалдаагаар зарагдах боломжгүй 23 авто тээврийн хэрэгслийг хаягдал гэж үзсэн бөгөөд тэдгээрээс 2.9 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 2 авто тээврийн хэрэгсэл тухайн байгууллагад сэлбэгээр ашиглагдаж байна. Харин 2 авто тээврийн хэрэгслийн хаягдлын үнийг төсөвт төвлөрүүлээгүйг аудитын явцад илрүүлж, орон нутгийн төсөвт 0.3 сая төгрөг төвлөрүүлсэн болно.

2018 онд түрээсийн орлогын төлөвлөгөө 98.6 хувийн биелэлттэй буюу орлогын төлөвлөгөө тасарсан нь түрээслэгч гэрээгээ цуцалснаас үүссэн байна. Түрээсийн орон сууцны орлогын төлөвлөгөө 2017, 2018 онд тасарсан нь түрээслэгчтэй байгуулсан гэрээ цуцалснаас үүссэн бөгөөд 2020 оны 11 сарын байдлаар 45 түрээслэгчээс 25 түрээслэгч 8.6 сая төгрөгийн түрээсийн төлбөр төвлөрүүлээгүй байгаа нь “Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх журам” болон орон сууцны түрээсийн гэрээг зөрчиж байх тул төлбөрийн акт тогтоолоо.

Орон нутгийг өмчийн хөрөнгийн үйл ажиллагаанаас орох орлого, зардлын тооцоо судалгааг тухай бүр хийж, авлага, өр төлбөр үүсгэхгүйгээр орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтад анхаарч, хяналт хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Ашиглаж эхлээгүй үндсэн хөрөнгөд элэгдэл тооцогдсоор байгаа нь УСНББОУС-17/үндсэн хөрөнгө/-ийн 71-д “үндсэн хөрөнгийг ашиглахад бэлэн болсон үеэс буюу өөрөөр хэлбэл, түүнийг удирдлагын зорилгоор үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож байршуулах болон шаардлагатай нөхцөлийг хангасан үеэс элэгдэл тооцно” гэж заасантай нийцэхгүй, өмнөх аудитаар гарсан алдаа давтагдсаар байгаад тодорхой шийдвэр гаргуулж, үр нөлөөг сайжруулаагүй байна.

2013-2019 оны хөрөнгө оруулалтаар бий болсон 6 байгууллагын 1,080.1 сая төгрөгийн анхны өртөгтэй, 995.8 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгийг ашиглаагүй буюу ашиглах боломжгүй болсон байна.

Ихэнх байгууллагууд хөрөнгө гадагш гаргахдаа зөвшөөрөл олгох баримт, тэмдэглэл үйлддэггүй байна.

23 байгууллагын 283.7 сая төгрөгийн анхны өртөгтэй, 137.3 сая төгрөгийн үлдэх өртөгтэй хөрөнгө эвдэрч ашиглагдахгүй болсон байтал элэгдэл дуусаагүй гэж үзэн актлах асуудлыг аймгийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлээгүй байна.

31 байгууллагын 1,552.1 сая төгрөгийн анхны өртөгтэй, үлдэх өртөггүй хөрөнгийн актлах, устгах асуудлыг шийдвэрлээгүй байна. Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2013 оны 159 дүгээр тогтоолоор “Өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажиллах журам”-ыг мөрдөж байна.

ТӨБЗГ “Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг 2018 онд шинэчилсэн боловч өмнөх үлгэрчилсэн журмын дагуу боловсруулан баталсан журамд одоо болтол өөрчлөлт оруулаагүй байна.

Байгууллага бүр өмч хамгаалах байнгын зөвлөлийг томилж ажиллуулсан байх боловч өмч хамгаалах байнгын зөвлөлүүд хэрхэн ажилладаг нь тодорхойгүй, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт хэрэгжүүлээгүй, тооллогыг үр дүнтэй зохион байгуулаагүй байна.

Байгууллагуудын удирдлага нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-д “төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна”, 67.2-т “өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэж заасныг бүрэн хэрэгжүүлдэггүй байна. Аудитаар 44 байгууллагын хөрөнгө эзэмшигчийн карт, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлийг тулгахад хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт, хамгаалалт хангалтгүй, агуулах эмх цэгцгүй байх бөгөөд нярвын ажлын байрны үндсэн зорилт болох байгууллагын өмч хөрөнгө болон хүлээн авсан бараа материалын хадгалалт, хамгаалалт, эмх цэгц, бүрэн бүтэн байдлыг хариуцах ажил хангалтгүй байна.

2017 онд ОНӨГ нь хөрөнгийн бүртгэл, ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулах сарын аян зохион байгуулан, хөрөнгийг кодтой болгон, зурагжуулах ажил зохион байгуулсан

боловч аудитын явцад тулган баталгаажуулалт хийхэд тухайн үеэс хойш шинэчлээгүй, тооллого хийсэн эсэх нь тодорхойгүй, хөрөнгө эзэмшигчийн картыг шинэчлээгүй зэрэг зөрчлүүд байсаар байна.

Аудитын явцад 44 байгууллагын хөрөнгийг тулган баталгаажуулахад 18 байгууллага зөрчилтэй байсан тул залруулах талаар заавар, зөвлөмж өгч ажиллалаа. 6 байгууллага 125,670.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн эд хариуцагчийн карт, бүртгэлийг шинэчилсэн бол 12 байгууллага 46,048.8 төгрөгийн хөрөнгийн бүртгэл хөтлөлтийг залруулаагүй тул ОНӨГ-т хариуцуулан албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2.3 Аудитын гол дүгнэлт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫГ МӨРДӨЖ БУЙ ХУУЛЬ, ЖУРАМТАЙ НИЙЦҮҮЛЭН ШИНЭЧИЛЖ, ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЖ, ҮР НӨЛӨӨГ САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

2.4 Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлын нэгтгэл

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн		Үүнээс			
		Тоо	Дүн	Зөвлөмж	Төлбөрийн акт	Албан шаардлага	Хууль хяналтын бусад байгууллагад шилжүүлсэн
А	1	2	3	4	5	6	7
1	Аймгийн Засаг дарга	1		1			
2	Аймгийн ИТХ	2		2			
3	ОНӨГ	5	2,924.4	2	1	2	
4							
	ДҮН	8	2,924.4	5	1	2	-